

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2017.10.02

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх “Гэр бүлийн зөвлөл”-ийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, алба, газруудын гэр бүлийн зөвлөл, хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцах зорилгоор аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу хуваарь гарган, байгууллагуудын гэр бүлийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, зохион байгуулагдсан үйл ажиллагааны хүрээнд зөвлөмж гарган, байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	100%
2	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулж, олон нийтэд зориулсан нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байна.	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, 3-р улиралд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн талаар нийт 120 иргэнд мэдээлэл хийгээд байна.	100%

3	Байгууллагын албан хаагчдын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил, сар, 7 хоногоор төлөвлөн хэвших, E-OFFICE программын хэрэглээг сайжруулах	Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөлт, ажлын хариуцлага, цаг ашиглалт, үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна.	Газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн албан хаагчдын E-OFFICE программын хэрэглээнд хяналт тавин ажилладаг бөгөөд шинээр томилогдсон 2 мэргэжилтэнд E-OFFICE программын хэрэглээний талаар зөвлөгөө өгснөөр бүх мэргэжилтнүүд өдөр тутмынхаа үйл ажиллагаанд E-OFFICE программыг ашиглаж байна.	100%
4	Төрийн албан хаагчид, гэр бүл, хүүхдүүдийн дунд зохион байгуулах сургалтын хэрэгцээг тодорхойлж, жилийн сургалтын хуваарь гарган хэрэгжүүлэх	Судалгаан дээр үндэслэн сургалтыг зохион байгуулсан байна.	3-р улирлын сургалтын төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын ЕБС-уудын 9-р ангийн 150 сурагчид “Харилцааны соёл” сэдвээр сургалт зохион байгууллаа.	100%
5	Хүүхдийн тусламжийн 108 утсыг сум, орон нутагт сурталчлан таниулж, 108 утсанд ирсэн санал хүсэлтийг хэрэгжүүлж, эргэх холбоог сайжруулан ажиллах	Хүүхдийн тусламжийн 108 утасны талаар олон нийт мэдээлэлтэй болж, эргэх холбоо сайжирсан байна.	2017 оны 3-р улиралд 108 утсанд ирсэн 4 гомдлын 2-ыг шийдвэрлэн хариуг хүргүүлж, 2-ыг тухайн сумдын хамтарсан багт шилжүүлэн, шийдвэрлэх шатандаа явж байна.	100%
6	Хурдан морьны уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах стандарт мөрдүүлж ажиллах	Уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал хангагдсан байна.	Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолоор 2017 оны 07 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Их мандал” говийн бүсийн хурдан морины уралдааны үеэр	100%

			уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллалаа. Тус уралдааны үеэр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Наадмын үеийн уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавьж ажиллах 11 хүний бүрэлдэхүүнтэй баг гарч, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллалаа. Уралдаанд 9 насны 767 хурдан морийг 337 уралдаанч хүүхэд унаж хурдлуулсан бөгөөд уралдаанч хүүхдийг 100 хувь гэнэтийн ослын даатгалд хамруулж, хамгаалалтын малгай, өвдөгч, тохойвч, цээживчтэй уралдаанд оролцуулав. Уралдааны үед гарааны төхөөрөмж дээр 3, уралдааны явцад 6, нийт 9 хүүхэд морь бүдрэх, булгих шалтгаанаас болж унасан боловч бэртэл гэмтэл авалгүй эмнэлгийн анхан шатны тусламжийг цаг алдалгүй яаралтай авсан. Унасан хүүхдийн бүртгэлийг газар дээр нь хийж баталгаажуулан	
--	--	--	--	--

			ажилласан.	
7	Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд зуны сургалт зохион байгуулах	Чуулганы шийдвэрийн дагуу ажил үйлчилгээ төлөвлөгдөн хэрэгжсэн байна.	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн эрсдлийн түвшинг бууруулах зорилготойгоор Дэлхийн зөн Дундговь ОНХХ, “Оюуны гэгээ” ТББ-тай хамтран Говийн ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургуулийн нийт 48 сурагчдыг хамруулан 3 сарын хугацаанд эрсдэлт зан үйлийг эерэгжүүлэх бүлгийн сургалтыг зохион байгуулан ажилласан. Сургалт эхлэхээс өмнө тус 48 хүүхдийн 29 нь өндөр эрсдэлтэй, 19 хүүхэд дунд эрсдэлтэй байсан бол сургалт зохион байгуулж дууссаны дараагаар өндөр эрдэлтэй хүүхэд 5-р, дунд эрсдэлтэй хүүхэд 8-р буурч өндөр эрсдэлтэй 24, дунд эрсдэлтэй 16, бага эрсдэлтэй 5 хүүхэд болж тус тус эрсдлийн түвшин буурсан.	100%
8	Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавьж ажиллах, сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор “Хүүхэд хууль-2017” тэмцээнийг аймгийн Засаг даргын тамгын газрын хууль эрх	100%

			зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Дундговь ОНХХ хамтран 7 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Багуудын мэндчилгээ, багийн гишүүдийн дундах хуулийн асуулт, сэдэвчилсэн жүжигчилсэн тоглолт, багийн ахлагч нарын дундах хуулийн асуултанд хариулах дарааллаар оноо өгөгдөж, тэмцээний тэргүүн байрыг ЭДЦС, дэд байрыг Хүмүүнлэг сургууль, гуравдугаар байранд МГСС-тай сургуулийн багууд тус тус шалгарсан. Тус тэмцээнийг зохион байгуулсны үр дүнд хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн 6.20-д заасан хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд цаашид авах арга хэмжээг сурагчид уншиж судлан хүүхэд хүүхэддээ нөлөөлсөн арга хэмжээ болсон.	
9	Хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилготой “Хүүхэд хамгааллын дэлхийн 7 хоног” аяныг зохион	Удирдамжийн дагуу аян зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Хүүхдийн эрхийн тухай конвенц, “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн хэрэгжилтийг дэмжин, нийгмийн бүх орчинд хүүхдийн хүчирхийлэл, бие махбодийн	100%

	байгуулах		шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлж, хамгаалах зорилготой “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын 7 хоногийн аяныг аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, БСУГ, ЦГ, Сайнцагаан сум, “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй хамтран Арвижих, Боржигон, Нарлаг, Айраг, Мандал худалдааны төвийн урд талд, спорт хорооны баруун талд, цагдаагийн гаднах талбайд нийт 6 гэр мэдээллийн төв барьж, 2159 насанд хүрэгч, 1687 хүүхэд нийт 3846 иргэнд, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Хүүхдийн тусламжийн утас 108, гэр бүлийн дүрэм бий болгох, хүүхдийн хөгжлийн онцлог, хүүхдийн аюулгүйн дүрмийг насны ангиллаар сургалт мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа.	
10	1.7 “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн нэр төрлийг нэмэгдүүлж, гадаад харилцааг өргөжүүлэх	Үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, амрагч хүүхдийн тоо өмнөх оныхоос 10-20%-иар өссөн байна.	Зусланд амрагч хүүхдийг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн нэр төрөл нэмэгдэж, 2017 онд 162 хүүхдийг зусланд амраасан нь өмнөх 2016 оноос 15%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	70%

			ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Эрээн хотын удирдлагуудтай зусланд амрагч хүүхдүүдийг харилцан солилцож амраах талаар аймгийн Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран ажиллаж байна.	
11	Хүүхдийн паркийн мөсөн гулгуурын талбайг томсгож шинэчлэх	Аюулгүй орчин бүрдэж, үйлчилгээний хүртээмж сайжирч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.	Хугацаа хойшилсон /4-р улиралд/	0%
12	Байгууллагын үйл ажиллагааг цахим, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан таниулж, ил тод байдлыг ханган ажиллах	Байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд сурталчлагдсан байна.	Тус байгууллага нь www.dundgovi.gov.mn , Дундговь ГБХЗХГ пэйж хуудас, орон нутгийн FM-ээр дамжуулан зохион байгуулж буй арга хэмжээнүүдийн 36 мэдээ, 5 шторк, 57 зурган мэдээллийг тухай бүрт нь олон нийтэд, сурталчилан ажиллаж байна. “Би аавтайгаа адилхан” фэйсбүүк уралдааныг амжилттай зохион байгууллаа. Мандал худалдааны төвийн гадна талбайд байрлах LED дэлгэцээр “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын 7 хоногийн аяны турш хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын	100%

			шторкууд, цацаж иргэдийг мэдээллээр ханган ажилласан.	
13	Шинээр батлагдсан “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийг залуучууд, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах	“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн талаар залуучууд, иргэд, олон нийт мэдлэгтэй болсон байна.	“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийг сурталчлах ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, хуваарийн дагуу албан байгууллагуудаар мэдээлэл хийн ажиллаж байна. 3-р улиралд БЗӨБЦТС-ийн 40 залууд мэдээлэл хүргээд байна. Мөн АС цогцолбороор 1 удаа хуулийн танилцуулгыг иргэд, олон нийтэд мэдээлээд байна.	100%
14	Залуучуудын чуулганыг зохион байгуулж, сум орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх	Залуучууд тулгамдсан асуудлаа дэвшүүлж, чуулганы шийдвэрийг хэрэгжүүлсэн байх Залуучуудын нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байх	Хугацаа хойшилсон /4-р улиралд/	0%
15	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар болон хүүхдийн байгууллагын албан хаагчийн үйл ажиллагааны талаар, байгууллага, хувь хүний амаар, бичгээр, цахим хэлбэрээр гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллах	Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна.	2017 оны 3-р улиралд нийт 21 санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авснаас амаар болон утсаар, 1 биечлэн уулзаж холбогдох газарт нь хүргүүлсэн өргөдөл 9, албан бичиг болон холбон зуучлалын маягтаар хариуг хүргүүлсэн 3, хугацаа болоогүй өргөдөл 2, ирснийг хүлээн авч холбогдох байгууллагад хандан хуулийн	100%

			хугацаанд хүргүүлээ. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 1, хүүхдийн эрх нь зөрчигдсөн 2 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, тусламж үзүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 иргэнд зөвлөгөө өгч хамтарсан багт холбон зуучилсан. Бусад /Томилолтын зардал хүсэх, чөлөө авах, ажилд орох хүсэлт, ажлаас гарах хүсэлт г.м/ 108 утсанд 3 дуудлага ирж холбогдох арга хэмжээг авч ажиллсан. Хамтран ажиллах санал ирүүлсэн байгууллагууд Цаг уур, ЭМГ, Дэлхийн зөн олон улсын байгууллага, БСУГазрууд байна. 2017 оны 3-р улиралд ГБХЗХГ-т ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг 87,5%-тай шийдвэрлэсэн хугацаа болоогүй 2 өргөдөл байна.	
16	Байгууллагын албан хаагчдыг дотоод болон гадаад сургалтуудад хамруулах	Албан хаагчдын мэдлэг, чадварын түвшин нэмэгдэж, ажлын байрандаа хөгжсөн байна.	-Газрын Нягтлан бодогч С.Чинбат 2017.09.21-09.25-ны өдрүүдэд Дорноговь аймагт “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” сэдэвт сургалтад хамрагдлаа. - Газрын дарга Ц.Ганзориг 2017.09.15-нд ХНХЯ, ЗГ-ын	100%

			хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас зохион байгуулсан “Гэр бүлийн үндэсний зөвлөгөөн” болон ЗГХЭГ-ын харьяа Удирдлагын академид 2017.10.11-10.13-ны өдрүүдэд “Нийгмийн салбарын удирдлагыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтад хамрагдлаа. -Газрын хүүхэд хөгжил хамгаалал, оролцоо хариуцсан мэргэжилтэн Б.Цэцэг 2017.09.18-10.06-ны өдрүүдэд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас зохион байгуулсан “Хүүхдийн эрхийн улсын байцаагч бэлтгэх” сургалтад хамрагдлаа. -Газрын Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч У.Уянга 2017.06.05-06.07-ны өдрүүдэд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас зохион байгуулсан гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадваржуулах сураглт болон 2017.08.25-08.28-ны өдрүүдэд “Угийн бичих хөтлөх арга зүй” үндэсний сургагч багш бэлтгэх 32 цагийн сургалтад хамрагдлаа.	
--	--	--	--	--

Хэрэгжилт гаргасан: Ахлах мэргэжилтэн

Ц.Энхбилгүүн

Хянасан: Дарга

Ц.Ганзориг